



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 37 (370)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Засгийн газрын бүрэлдэхүүний тухай*
- *Засгийн газрын бүтцийн тухай*
- *Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны аравдугаар сарын 4

№ 37 (370)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

366.	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай		703
367.	Засгийн газрын бүтцийн тухай		703
368.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		704

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

369.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай	Дугаар 14	707
370.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай	Дугаар 15	710
371.	Сонгуулийн зардлын хэмжээ батлах тухай	Дугаар 16	710
372.	Хууль, тогтоолын төсөл батлах тухай	Дугаар 17	711
373.	Улсын Их Хурлын 2004 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 18	711

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

374.	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 161	714
------	---	------------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар тогтоосугай:

- 1/ Монгол Улсын Ерөнхий сайд;
- 2/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Монгол Улсын шадар сайд;
- 3/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Байгаль орчны сайд;
- 4/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Батлан хамгаалахын сайд;
- 5/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Барилга, хот байгуулалтын сайд;
- 6/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;
- 7/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Гадаад хэргийн сайд;
- 8/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Зам тээвэр, аялал жуулчлалын сайд;
- 9/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;
- 10/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Сангийн сайд;

- 11/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Түлш, эрчим хүчний сайд;
- 12/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Үйлдвэр, худалдааны сайд;
- 13/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- 14/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Хүнс, хөдөө аж ахуйн сайд;
- 15/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Эрүүл мэндийн сайд;
- 16/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Засгийн газрын Хэрэг зрхлэх газрын дарга;
- 17/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Монгол Улсын сайд;
- 18/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Монгол Улсын сайд;

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн:

- 1/ Гадаад хэргийн яам;
- 2/ Сангийн яам;
- 3/ Хууль зүй, дотоод хэргийн яам.

Чиглэлийн:

- 4/ Байгаль орчны яам;
- 5/ Барилга, хот байгуулалтын яам;
- 6/ Батлан хамгаалах яам;
- 7/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;

- 8/ Зам тээвэр, аялал жуулчлалын яам;
- 9/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 10/ Түлш, эрчим хүчний яам;
- 11/ Үйлдвэр, худалдааны яам;
- 12/ Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- 13/ Эрүүл мэндийн яам.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 9 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн

- 1/ Гадаад хэргийн яам;
- 2/ Сангийн яам;
- 3/ Хууль зүй, дотоод хэргийн яам.

Чиглэлийн

- 4/ Байгаль орчны яам;
- 5/ Барилга, хот байгуулалтын яам;
- 6/ Батлан хамгаалах яам;
- 7/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 8/ Зам, тээвэр, аялал жуулчлалын яам;
- 9/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 10/ Түлш, эрчим хүчний яам;
- 11/ Үйлдвэр, худалдааны яам;
- 12/ Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- 13/ Эрүүл мэндийн яам.

2/ 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд дараахь асуудал хамаарна:

- мэдээлэл, харилцаа холбоо, өндөр технологийн асуудал;
- төрийн өмчийн бодлого;
- тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, асуудал.

3/ 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Засгийн газрын гишүүн дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

1/ Монгол Улсын Шадар сайд:

- бүс нутгийн хөгжлийн бодлого;

- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал
- стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах асуудал;
- хүүхэд, залуучуудын асуудал.

2/ Монгол Улсын Гадаад хэргийн сайд:

- гадаад орон, олон улсын байгууллагатай улс төрийн талаархи хамтын ажиллагаа;
- гадаад эдийн засгийн харилцаа;
- гадаадад байгаа Монгол Улсын иргэд, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;
- виз, консулын асуудал;
- гадаад орон, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээр хамтын ажиллагаа;
- гадаад орон, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал, байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт.

3/ Монгол Улсын Сангийн сайд:

- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын нэгдсэн төсвийн талаархи судалгаа, төлөвлөлт;
- улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;
- төсвийн хөрөнгө оруулалтын бодлого;
- зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
- бүртгэлийн нэгдсэн тогтолцооны удирдлага;
- гаалийн бодлого;
- татварын бодлого;
- даатгалын бодлого;
- санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал.

4/ Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд:

- эрх зүйн шинэтгэлийн бодлого;
- хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;
- эрх зүйн туслалцаа;
- архивын талаар төрөөс баримтлах бодлого;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- иргэний болон иргэний гэр бүлийн бүртгэл, мэдээлэл, иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
- хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагын бүртгэл;
- төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
- Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, нотариат, өмгөөллийн олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;
- цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал;
- улсын хил хамгаалалтын асуудал;
- төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт.

5/ Монгол Улсын Байгаль орчны сайд:

- байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
- цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;
- усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;
- газрын хэвлийн баялаг, ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан;

- байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн бэлэглэл, гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал.

6/ Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайд:

- барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн асуудал;
- хот байгуулалт, архитектурын асуудал;
- орон сууцны бодлогын асуудал;
- нийтийн аж ахуйн асуудал;
- барилгажих талбай, газрын асуудал;
- газар зохион байгуулалтын удирдлага, геодези, зураг зүй, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн асуудал.

7/ Монгол Улсын Батлан хамгаалахын сайд:

- улсыг батлан хамгаалах болон цэргийн бодлого;
- зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;
- энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал.

8/ Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд:

- боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал;
- соёл, урлагийг хөгжүүлэх, түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;
- ном хэвлэл, цахим бичвэрийн бодлого;
- шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын асуудал;
- шинжлэх ухаан, технологийн мэдээлэл.

9/ Монгол Улсын Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд:

- тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, уялдааг

сайжруулах асуудал;

- төмөр замын тээврийн асуудал;
- иргэний нисэхийн асуудал;
- авто тээврийн болон авто замын асуудал;
- далайн болон усан замын тээврийн асуудал;
- шуудангийн үйлчилгээ;
- аялал жуулчлалын бодлого.

10/ Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд:

- хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;
- хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын ертгийн талаархи судалгаа;
- хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;
- хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;
- нийгмийн халамжийн бодлого;
- нийгмийн даатгалын бодлого;
- хүн ам зүйн бодлого;
- Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;
- гадаадад ажиллах хүч гаргах асуудал;
- хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт.

11/ Монгол Улсын Түлш, эрчим хүчний сайд:

- эрчим хүчний нэгдсэн бодлого;
- түлш, эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;
- сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;
- бүс нутгийн түлш, эрчим хүчний асуудал;
- эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого.

12/ Монгол Улсын Үйлдвэр, худалдааны

сайд:

- геологи, эрдэс баялгийн бодлого;
- үйлдвэрлэлийн технологийн бодлогын асуудал;
- экспорт, импортын асуудал;
- гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах асуудал;
- газрын тосны талаархи бодлого;
- худалдааны бодлого зохицуулалт;
- эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого.

13/ Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн

сайд:

- хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- мал аж ахуй болон газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- мал, амьтан, ургамлын хорио цээрийн асуудал;
- хөнөөлт мэрэгчтэй тэмцэх асуудал;
- мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эдийн экспорт, импортын асуудал;
- хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;
- малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого.

14/ Монгол Улсын Эрүүл мэндийн сайд:

- хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;
- эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаархи бодлого;
- эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;
- биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;



- хүн амын эрүүл мэндийг хамгаалах нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ.

15/ Монгол Улсын сайд-Засгийн газрын

Хэрэг эрхлэх газрын дарга:

- Засгийн газрын шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын дотоод мэдээлэл;
- Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал;
- орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлага;
- иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа;
- Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал.

16/ Монгол Улсын сайд:

- гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал;
- хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал.

17/ Монгол Улсын сайд:

- тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг хавсралтаар баталсугай.

2.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж Улсын Их Хурлын 2004 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 58 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

Н.ЭНХБАЯР



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд	1. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар 2. Тагнуулын ерөнхий газар 3. Төрийн өмчийн хороо	
Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	4. Стандартчилал, хэмжил зүйн төв 5. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар	1. Оюуны өмчийн газар 2. Хүүхдийн төлөө үндэсний газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		3. Удирдлагын академи 4. Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		5. Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		6. Улсын гаалийн ерөнхий газар 7. Үндэсний татварын ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	6. Хил хамгаалах ерөнхий газар 7. Цагдаагийн ерөнхий газар	8. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв 9. Үндэсний архивын газар 10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		11. Ой, усны нөөцийн газар 12. Ус, цаг уур, орчны шинжилгээний газар



Монгол Улсын Их Хурлын 2004 оны
14 дугаар тогтоолын хавсралт

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	9. Зэвсэгт хүчний жанжин штаб	
Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		13. Иргэний нисэхийн ерөнхий газар 14. Төмөр замын Хэрэг эрхлэх газар
Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		15. Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар 16. Гадаадын хөрөнгө оруулалтын газар
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		17. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар 18. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		19. Биеийн тамир, спортын улсын хороо
Монгол Улсын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	10. Улсын мэргэжлийн хяналтын газар	
Монгол Улсын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	11. Гамшгаас хамгаалах ерөнхий газар	



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин явуулахаар 2004 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12, Аймаг, эхлэн товлон зарласугай.

нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолыг 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг 2004 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн ням гаригт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Сонгуулийн зардлын хэмжээ батлах тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Дээрх зардлын 112,477.3 мянган 3.Энэ тогтоолыг 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2004 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 545,755.0 мянган төгрөгөөр тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Хууль, тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 3 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өргөн мэдүүлэгдсэн болон хэлэлцэж шийдвэрлээгүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийн санаачлагч

өөрчлөгдсөн, эдгээр төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын санал авах шаардлагатай байгаа зэргийг харгалзан хавсралтад дурдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг хууль санаачлагчид буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2004 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байнгын хороод, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2004 оны намрын ээлжит чуулгангаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2/ Монгол Улсын 2005 оны улсын төсвийн тухай хуулийн төсөл;

3/ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/ Үндэсний олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төсөл;

6/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7/ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8/ Бусад.

2. Улсын Их Хурлын 2004 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Н.Лувсанжав/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

ТӨСӨЛ САНААЧЛАГЧИД БУЦААХ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД

1. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд.

2. Авилгалын эсрэг хуулийн төсөл болон Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд.

3. Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын тухай хуулийн төсөл.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

6. Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

7. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төсөл.

8. Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

9. "Төрийн ордон, түүний орчныг тохижуулахтай холбогдон авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын төсөл.

10. Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд.

11. "Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны дүрэм батлах тухай" болон "Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай" УИХ-ын тогтоолын төслүүд.

12. "Албан бус хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны талаар баримтлах бодлого батлах тухай" УИХ-ын тогтоолын төсөл.

13. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Химийн

хорт бодисоос хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны аймгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан, амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

14. Монгол Улсад байнга оршин суугаа ОХУ-ын цагаач иргэдийн орон сууцныг үнэ төлбөргүй хувьчлах тухай Монгол Улсын болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

15. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд

зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

16. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

17. Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

18. "Батлан хамгаалах хэрэгцээнд олгох тусгай хэрэгцээний газрын жагсаалтыг батлах тухай" УИХ-ын тогтоолын төсөл.

19. Чингис хаан нэр ашигласны төлбөрийн тухай хуулийн төсөл болон Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

20. "Чингис хаан" нэр, Чингис хааны хөргийг хэрэглэх тухай хуулийн төсөл.

21. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

22. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

23. Техникийн хамтын ажиллагааны тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 7 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хилийн болон дотоодын цэргийн" гэж тус тус өөрчилсүгэй.

1. "Дүрэмт хувцас, хэрэглэлийн нормыг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл болон мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын гарчгийн "Зэвсэгт хүчин, дотоодын цэрэг, хилийн цэргийн" гэснийг "Ерөнхий зориулалтын цэрэг,

2. Мөн тогтоолын 1 дүгээр хавсралтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

а/хавсралтын "Дээд офицер /маршал, генерал/-ын хувцас, хэрэглэл" гэсэн 1 дэх хэсэгт дор дурдсан 24-29 дэх заалт нэмэх:

24	Дугуй малгай	ш	1	3
25	Ноосон цамц	ш	1	3
26	Футболка /эрээн/	ш	1	8 сар
27	Өмдний тэлээ	ш	1	5
28	Саан зүүлт	ш	1	1 удаа
29	Даавуун оймс	ш	2	1

б/хавсралтын "Дээд офицер /маршал, генерал/-ын хувцас, хэрэглэл" гэсэн 1 дэх хэсгийн "Каракуль захтай, өдөр тутмын өвлийн хувцас" гэсэн 15 дахь заалтын эдлэх хугацааг "5" гэснийг "7" гэж, "Хагас түрийтэй ботинк" гэсэн 18 дахь

заалтын эдлэх хугацааг "5" гэснийг "3" гэж тус тус өөрчлөх;

в/хавсралтын "Офицер, ахлагчийн хувцас, хэрэглэл" гэсэн 2 дахь хэсэгт дор дурдсан 26-32 дахь заалт нэмэх:

26	Дугуй малгай	ш	1	3
27	Ноосон цамц	ш	1	3
28	Футболка /эрээн/	ш	1	8 сар
29	Өмдний тэлээ	ш	1	5
30	Саан зүүлт	ш	1	1 удаа
31	Даавуун оймс	ш	2	1
32	Хагас түрийтэй өвлийн ботинк	хос	1	3

г/хавсралтын "Офицер, ахлагчийн хувцас, хэрэглэл" гэсэн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, "Ёслол /алба/-ын саравчтай малгай" гэснийг "Ёслолын малгай" гэж, мөн заалтын эдлэх хугацааг "3" гэснийг "7" гэж, мөн хэсгийн "Каракуль захтай, савхин гадартай, салдаг дотортой хагас богино дээл /хурандаад/" гэсэн 13 дахь заалт, "Цегейк захтай, савхин гадартай, салдаг дотортой хагас богино дээл /офицер, ахлагч нарт/" гэсэн 14 дэх заалтын эдлэх хугацааг "5" гэснийг "7" гэж, "Зуны ботинк" гэсэн

19 дэх заалтын эдлэх хугацааг "1" гэснийг "2" гэж, мөн хэсгийн тайлбарын 3-т "120" гэснийг "084" гэж, мөн тайлбарын 5-д "эсгий гутлын эдэлгээний хугацааг 2 жилээр тооцно" гэснийг "эсгий гутлыг 2 жилээр тооцож олгоно" гэж тус тус өөрчлөн, мөн хэсгийн "Эсгий гутал" гэсэн 17 дахь заалтыг хасах;

д/хавсралтын "Цэргийн их сургуулийн сонсогчийн хувцас, хэрэглэл" гэсэн 3 дахь хэсэгт дор дурдсан 13 дахь заалт нэмэх:

13	Даавуун оймс	хос	2	1
----	--------------	-----	---	---

е/хавсралтын "Цэргийн их сургуулийн сонсогчийн хувцас, хэрэглэл" гэсэн 3 дахь хэсгийн гарчгийг "Цэргийн сургуулийн сонсогчийн хувцас,

хэрэглэл" гэж, мөн хэсгийн "Хагас түрийтэй ботинк" гэсэн 10 дахь заалтын эдлэх хугацааг "2" гэснийг "1 жил 6 сар" гэж, мөн хэсгийн тайлбарын 1-д

"Цэргийн их сургуулийн" гэснийг "Хилийн цэргийн дээд сургуулийн" гэж, 2-т "Цэргийн их сургуульд" гэснийг "Цэргийн сургуульд" гэж тус тус өөрчлөх;

ж/хавсралтын "Шалган нэвтрүүлэх албаны офицер, ахлагчийн хувцас, хэрэглэл" гэсэн 4 дэх хэсгийн "а"-гийн 2 дахь заалтын эдлэх хугацааг "3" гэснийг "7" гэж өөрчлөх;

з/хавсралтын "Гэрээт цэргийн албан хаагчийн хувцас, хэрэглэл" гэсэн 5 дахь хэсгийн "Хагас түрийтэй ботинк" гэсэн 8 дахь заалтын эдлэх

хугацааг "2" гэснийг "1" гэж өөрчлөх.

3. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтад дор дурдсан 31 дэх заалт нэмсүгэй:

А	1	2	3	4	5	6	7
31	Дугуй малгай	Оройн өнгө Материал Эмжээрийн өнгө Материал Тохируулах туузны өнгө Материал	Хар ногоон, хүрэн улаан Одончуу Хар Савхи Хар Торгомсог	Хар ногоон, хүрэн улаан Одончуу Хар Савхи Хар Торгомсог			

4. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтын 1, 6, 18 дахь заалтын 2 дэх баганын "хүрээний өнгө материал" гэснийг "хавчуурга материал" гэж, 3 дахь заалтад "Нарнаас хамгаалах малгай" гэснийг "Нарнаас хамгааллах бүрх малгай" гэж, мөн хавсралтын тайлбарын 1-д "Зэвсэгт хүчний ерөнхий штаб, Улсын иргэний хамгаалалтын газар, ГХМСТГ-ын" гэснийг "Ерөнхий зориулалтын цэргийн" гэж тус тус өөрчлөн, 1, 18 дахь заалтын 4 дэх баганын "улаан, ногоон" гэсний дараа "хүрэн улаан" гэж, 3 дахь заалтын 3, 4 дэх багананд "бор шаргал

өнгөлөн далдлалтын хагас ноосон даавуу" гэж тус тус нэмэх.

Монгол Улсын
Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Батлан хамгаалахын
сайд

Ж.ГУРРАГЧАА